


“ГУРАВ ДАХЬ ХҮЧИН” эвслийн 2012 оны 5-р сарын 2-ны

өдрийн хурлын 32 тоот тогтоолоор батлагдсан



“ГУРАВ ДАХЬ ХҮЧИН”

ЭВСЭЛ

(БҮГД НАЙРАМДАХ НАМ, ХАМУГ МОНГОЛЫН ХӨДӨЛМӨРИЙН НАМ)

“МОНГОЛ УЛСАА АВРАХ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР”

2012 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛЬ

Эвслийн уриа:

“УЛС МОНГОЛДОО – ШИНЭ ТӨР

АРД ТҮМЭНДЭЭ – ЧИНЭЭЛЭГ АМЬДРАЛ

ЭХ НУТАГТАА – УНАГАН ТӨРХ”

АГУУЛГА:

Нэг	Улс төрийн хувьсгал – Шинэ төр
Хоёр	Шинэ эдийн засаг – Хөгжлийн ирээдүй
Гурав	Нийгмийн бодлого – Иргэн бүрт
Дөрөв	Боловсрол, Хүмүүжил – Хөгжлийн түлхүүр
Тав	Эрүүл Монгол хүн – Аз жаргалтай амьдрал
Зургаа	Үйлдвэржилт – Амьдралын баталгаа
Долоо	Хөдөө Аж Ахуй – Ногоон бүс, аюулгүй хүнс
Найм	Дэд бүтэц, Ардын орон сууц – Хүний төлөө
Ес	Гадаад харилцаа – Сайн хөршийн түншлэл



ОРШИЛ

Монгол Улсын хөгжил, улс төр, эдийн засаг, нийгмийг эрүүл шинэ бодлогоор бүрэн тодорхойлж Монгол төрийг бэхжүүлэн хүчирхэг Монгол Улсыг байгуулахдаа "МОНГОЛ ХҮН" –ийг бодлогынхоо төвд ямагт байлгаж, авъяас билгээ хөгжүүлэх, бүтээлч, шударга хөдөлмөрөөрөө хувийн өмчөө арвижуулах, үндэсний баялгаа нэмэгдүүлэн Монгол хүний амьдралын баталгааг бүрэн хангах зорилгоор "МОНГОЛ УЛСАА АВРАХ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР"–өө "ГУРАВ ДАХЬ ХҮЧИН" эвсэл ард түмэндээ өргөн барьж байна.

НЭГ. УЛС ТӨРИЙН ХУВЬСГАЛ – ШИНЭ ТӨР

1.1. Монгол оронд зөвхөн Монгол хүн нэгдүгээрт байхыг Үндсэн Хуулиар баталгаажуулна.

1.2. Зөвхөн Монгол хүний аз жаргалтай, хүмүүнлэг амьдралын төлөө хүчтэй төрийг байгуулна.

1.3. Монгол хүний эрх чөлөөний дайсан болсон намт-төрийг татан буулгаж ард түмний төрийг байгуулна. Монголын улс төрийн намуудыг гишүүнчлэлгүй, өмч хөрөнгөгүй болгоно. Ингэснээр Монгол хүний эрх чөлөө баталгаажиж, өөрөө өөртөө эзэн байж, итгэл дүүрэн, бардам амьдрах нөхцөл бүрдэх юм.

1.4. Төрийн ардчилсан бүтцийг бий болгоно. Үүний тулд Ардчиллын гурван багана болсон Парламент, Засгийн газар, Шүүх засаглалын бие даасан байдлыг хэрэгжүүлнэ.

1.5. Засгийн газрын бүтцийг бүрэн шинэчилж хөгжлийн бодлогыг төрийн хэтийн төлөвлөлттэй уялдуулан явуулдаг тогтолцоог хэрэгжүүлнэ.

1.6. Ардчиллын гурван үнэт зүйл болох эрх чөлөө, тэгш эрх, эв нэгдэл гурвыг төрийн үйл ажиллагаанд бүрэн гүйцэд хэрэгжүүлэхийг зорилго болгоно.

1.7. Төрийн эрх мэдлийг ашиглаж өөрийн төлөө, өөрийн гэр бүл, үр хүүхэд хамаатан садан, хамсаатанг хөрөнгөжүүлэх зорилгоор төрийн өмч, төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл тусламжийг шамшигдуулдаг хэлбэрээр илэрч байгаа олигархийн тогтолцоо нь Монгол үндэстэн цаашлаад хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг төдийгүй нийт ард түмний сайн сайхан амьдрах боломжийг хааж байгаа тул олигархиудыг Монголын улс төрөөс цэвэрлэнэ.



1.8. Ардчилсан орнуудын засгийн газрууд, олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж гадаад дотоодод байгаа олигархиудын үл хөдлөх хөрөнгө, хувьцаа болон хадгаламжийг олон нийтэд ил тод болгоно.

1.9. Олигархиудын гар хөл болсон хэвлэл мэдээллийн байгууллагууд, олон нийтийн байгууллагуудыг хуулийн хариуцлага хүлээлгэнэ.

1.10. Монгол үндэстний эсрэг оюуны терроризмыг бүрэн таслан зогсоох зорилгоор мухар сүсэг, худал мэдлэг, дутуу мэдлэг, алдаатай мэдлэгээр ард түмний толгойг угаадаг бүх үйл ажиллагааг таслан зогсооно.

1.11. Монгол оронд шударга хөдөлмөр эрхлэж байгаа гадаадын иргэдийг авилгалчдаас хамгаална.

1.12. Улс төр, нийгэм эдийн засгийн бүх хүрээнд Монгол үндэстнийг мэдлэгт тулгуурласан нийгэмд шилжүүлэх үндэстний хөдөлгөөнийг бүх бүс нутагт нэг зэрэг төлөвлөгөөтэй хэрэгжүүлнэ.

1.13. Шүүх, прокурор болон цагдааг нам, улс төрийн хүчнээс ангид байлгаж, шударга ёсны зарчмыг хэрэгжүүлнэ. Ардчилал нэгэнт ард түмнийг төрийн эзэн гэдэг тул ямар ч шүүхийн болон хуулийн байгууллагууд тогтоол шийдвэрээ “ард түмний нэрийн өмнө”-өөс гэсэн үгээр төгсгөх ёстой.

1.14. Сонгуулийн хуулинд төр ба ард түмний хооронд гэрээ байгуулах заалтыг нэмж оруулах ба ингэснээр төрд ард түмний хяналтыг тогтоож, хариуцлагатай улс төрийг бий болгоно.

ХОЁР. ШИНЭ ЭДИЙН ЗАСАГ – ХӨГЖЛИЙН ИРЭЭДҮЙ

2.1. Улсын төсвийн орлого, зарлагын хяналтыг ил тод болгон сайжруулж хариуцлага тооцдог болгоно. Төсвийн орлогыг эрс нэмэгдүүлэх дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

2.2. Олигархийн тогтолцоог бүрэн устгах зорилгоор төсвийн хөрөнгөөр хэрэгжих төслүүдийг зөвхөн хувьцааных нь 90-ээс багагүй хувийг хөрөнгийн биржээр арилжаалсан олон нийтийн хяналтан дор үйл ажиллагаагаа явуулдаг нийтийн өмчит аж ахуйн нэгжүүд дунд тендер зарлаж гүйцэтгүүлнэ.

2.3. Монгол хүний эд хөрөнгийг үнэгүйдүүлж, Монгол хүний хөдөлмөрийг мөлждөг Монгол үндэстний эсрэг гэмт хэрэг болсон банкны хүүгийн боолчлолыг таслан зогсоож шударга хөдөлмөрөөр амьдрах бололцоог буй болгоно.



2.4. Банкны зээлийн хүүг олон улсын жишигт хүргэж бизнест урт хугацааны зээл олгох боломжийг бүрдүүлнэ.

2.5. Татварын бодлогыг шинэчилнэ.

2.6. Монголд үйлдвэрлэж байгаа бараатай ижил төрлийн барааны импортын татварыг нэмэгдүүлж дотоодын аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.

2.7. Орон нутгийг хөгжүүлэх хөгжлийн санг байгуулж орон нутгийн бие даасан эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлнэ.

2.8. Санхүү, хөрөнгө оруулалт болон даатгалын системийг олон улсын жишигт хүргэж иргэн бүрт хүртээлтэй болгоно.

2.9. Даатгалын системийг бүхэлд нь өөрчилнө. Тухайлбал өндөр настны асрамжийн даатгалыг шинээр бий болгоно.

2.10. Нийтийн албан хаагчийн цалин хангамж, хариуцлагыг хөгжингүй орны жишигт хүргэнэ.

2.11. Эдийн засгийн болон хамтын дэг журмыг онцлон хэрэгжүүлнэ. Чөлөөт зах зээлийн эдийн засаг биш харин дэг журамтай, хяналттай хамтын зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэхийн төлөө ажиллана. Үүнийг хамтын эрх ашигт зориулан хэрэгжүүлнэ. Нийтийн эрх ашгийг хувийн эрх ашгаас дээгүүр тавина.

2.12. Эдийн засгийг улс ардын аж ахуйтай хослуулан олсон ашгийг тэгш зарчим дээр тооцох. Эдийн засгийг зөвхөн банк, санхүүгийн бүтцээр тайлбарлах биш, улс ардын аж ахуйн бүтээн байгуулалтаар залруулна.

2.13. Уул уурхай хэзээд Монголын ард түмний хөрөнгө байх болно. Ашигт малтмалыг тооцоотой хэрэглэнэ. Уул уурхайн лиценз бол хэзээ ч өмчлүүлэх лиценз биш. Лиценз зөвхөн ашигт малтмалыг хэрхэн эдийн засгийн ашигтай ашиглуулж Монгол улсын санхүүгийн чадварыг дээшлүүлэхэд л хэрэглэх зорилготой.

2.14. Мэдлэгт суурилсан Хөдөө аж ахуйг улс орны тэжээгч эдийн засгийн түвшинд зохицуулан хүргэх. Монгол улсын хөдөө аж ахуйг бүрдүүлэгч гол хоёр салбар болох мал аж ахуй болон газар тариаланг нийт хүн амын хоол хүнс болон эрүүл амьдрах гол тэжээгч эдийн засгийн түвшинд хүргэж хөгжүүлнэ. Ингэснээр хүнсний бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээг хангаж, гаднаас хамааралгүй болгоно.

2.15. Улс төр, нийгэм эдийн засгийн бүх хүрээнд Монгол үндэстнийг мэдлэгийн эдийн засагт шилжүүлэх үндэстний хөдөлгөөнийг бүх бүс нутагт нэг зэрэг төлөвлөгөөтэй хэрэгжүүлнэ.



2.16. Монгол улсын эдийн засгийг биеэ даасан хийгээд дэлхийн хэмжээнд өрсөлдөхүйц болгохын тулд гадаад валютын нөөц, тэтгэвэр, нийгмийн даатгалын сангуудын хуримтлалаас болон байгалийн баялгийн ашиг орлогоос бүрдсэн Үндэстний баялгийн хөрөнгө оруулалтын сангуудыг байгуулна. Үндэстний хөрөнгө оруулалтын сангууд нь Монгол улсын одоогийн болон ирээдүйн хөгжил дэвшлийг ханган, Монгол улсыг дэлхийн хэмжээний хүчирхэг эдийн засагтай байлгах гол нөхцлийг хангаж өгнө.

2.17. Хүн амын бодит орлого, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, дундаж орлоготой айл өрхийн тоог 70 хувьд хүргэж, дундаж давхаргыг нийгмийн зонхилох хэсэг болгох эдийн засаг, нийгмийн нөхцлийг бүрдүүлнэ.

2.18. Эдийн засаг дахь төрийн зохицуулалтыг боловсронгуй болгож, бизнест дарамт учруулж буй хууль тогтоомж, журмыг өөрчлөн шинэчилж, лиценз, тусгай зөвшөөрөл олголт, мэргэжлийн хяналтын үүргийг төрийн бус салбарын холбоодод шилжүүлнэ.

2.19. Банк, санхүүгийн тогтолцоог эрүүлжүүлж, банкны байгууллагаас үзүүлэх санхүүгийн үйлчилгээг өндөр хөгжилтэй орнуудын жишигт хүргэнэ. Арилжааны банкны дүрмийн санг нэмэгдүүлж, төлбөрийн чадварыг сайжруулан, банк, санхүүгийн зах зээлд шударга өрсөлдөөн төлөвшүүлэхийн зэрэгцээ экспортын үйлдвэрлэлийг дэмжих зорилготой экспорт-импортын банк байгуулж, Улаанбаатар хотыг бүс нутгийн хэмжээний банк, санхүүгийн томоохон төв болгох эдийн засгийн орчинг бүрдүүлнэ.

2.20. Гол нэрийн хүнсний барааны бодит үнийг тогтвортой барих төрийн бодлогыг цаг алдалгүй хэрэгжүүлнэ.

2.21. Даяарчлагдсан дэлхийд үндэстний оршин тогтнох гол хүчин зүйл бол тухайн үндэстний төр нь улс дамнасан эдийн засгийн үйл ажиллагааг явуулах институтын тогтолцоог буй болгож хэр зэрэг үр бүтээмжтэй ажиллаж байгаагаас шалтгаалдаг. Тиймээс үүнийг хэрэгжүүлэхийн тулд улс дамнасан үйл ажиллагаа явуулдаг төрийн хөрөнгө оруулалтын санг байгуулна.

2.22. Монголын үндэстний уламжлалт мал аж ахуйг орчин үеийн жуулчны аж үйлдвэртэй хослуулан экологийн тэнцвэртэй мэдлэгт тулгуурласан ногоон эдийн засгийн салбар болгон эко-туризмыг хөгжүүлнэ.

2.23. Экологийн сүйрэл авчирч буй эдийн засгийн үр ашиг муутай уул уурхайн замбараагүй ашиглалтыг зогсоож стратегийн ач холбогдолтой том орд газруудыг үе шаттайгаар одоогийн ба ирээдүйн үед хүртээмжтэй зарчмаар ашиглана.



2.24. Үндсэн Хуулийн 6-1-т заасан “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэсэн заалтын дагуу бүх лицензүүдийг түтгэлзүүлэн авч Монголын ард түмний нийтийн өмчит Үндэстний корпорациудыг байгуулж Монголтой нөхөрсөг, найрамдалт харилцаатай улсуудтай хамтран ажиллана.

2.25. Улсын хөрөнгөөр хайгуул хийж нөөцийг тогтоосон стратегийн орд газруудын жагсаалтыг өргөтгөн төрийн эзэмших хувийг 51%-иас доошгүй байх зарчмийг хатуу баримтлана.

2.26. Улсын төсвөөс хөрөнгө гаргаж шинээр геологийн хайгуул хийж шинээр ашигт малтмалын ордыг нээх нөөцийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.

2.27. Стратегийн орд газруудыг эдийн засгийн эргэлтэнд оруулан бий болгосон хуримтлалын зарим хэсгээр төрийн мэдлийн хөрөнгө оруулалтын “Чингисийн Монгол” сан байгуулж, олон улсын санхүүгийн зах зээлд эргэлтэнд оруулан улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгахад зохистой ашиглана.

2.28. Газрын тосны бүтээгдэхүүний олборлолтыг нэмэгдүүлж, газрын тос боловсруулах, шатдаг занар, хүрэн нүүрснээс хий, шингэн түлш үйлдвэрлэн дотоодын хэрэгцээг хангахын тулд ойрын, дундын, урт хугацааны бодлогыг хэрэгжүүлнэ. Газрын тосны бүтээгдэхүүний импортыг төрийн мэдэлд авч, төрийн нөөцийн агуулахын аж ахуй байгуулан үнийн хөөрөгдлөөс сэргийлэх нөхцлийг бүрдүүлнэ.

2.29. Хөрөнгийн биржийн үйл ажиллагааны цар хүрээг тэлж амжилттай ажилллаж байгаа эх орны аж ахуйн нэгжүүдийг үнэт цаасны зах зээлд өргөнөөр хамруулахад онцгой анхаарна.

2.30. Хөдөө аж ахуйн бирж ажиллуулна.

ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО – ИРГЭН БҮРТ

3.1. Нийгмийн бодлогыг зорилтот бүлэгт чиглүүлэн боловсруулна.

3.2. Ядуурлын эсрэг дайн зарлаж чинээлэг дундаж давхаргыг нийгмийн зонхилох хэсэг болгох нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3. Хөдөлмөрийн хөлсийг цагаар тооцдог тогтолцоонд шилжиж, цагийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих эдийн засгийн орчинг бүрдүүлнэ. Ахимаг насны буюу 40-өөс дээш насны хүмүүсийн ажил эрхлэлтийг дэмжих бодлого явуулна



3.4. Монголын ард түмнийг боолчилсон халамжийн бодлого гэгчийг таслан зогсоож хүмүүнлэг, хөгжилд тулгуурласан нийгмийн халамжийн тогтолцоог цогцлоон байгуулна.

3.5. Өмч болон эрх мэдлийг “шударга ёс” зарчим дээр тулгуурлан түүнд таарсан бодлого явуулах. Өмчийг хуваарилах мөн эрх мэдлийг хуваарилахдаа улс төрийн “шударга ёс”-ны зарчмыг барина. Иргэн бүрийн өмчтэй байх эрх болон боломжийг баталгаажуулах.

3.6. Хамтран оршин тогтнох хариуцлагыг иргэдэд сурталчилах. Хот суурин газар хамтран амьдарч нийгмийн бүтцийг бүрдүүлэхдээ нэг нэгнийгээ хүндэтгэж бусдын өмнө алдаагаа ухамсарлаж, иргэд хоорондоо хариуцлагатайгаар нийгмийн амьдралд оролцох ёстой үндэстний тогтолцоог бий болгоно.

3.7. Иргэн бүрийн нийгэмд оролцох оролцоо, төрөөс хүртэх халамж болон өмч өмчлөх харьцаануудад шинээр тэгшитгэл явуулах улс төрийн бодлого барина.

3.8. Эрэгтэйчүүд, эхчүүд болон гэр бүл, залуучуудын талаарх бодлогыг “эв нэгдэл” гэсэн зарчим дээр хэрэгжүүлэх. Ардчиллын жилүүдэд мэргэжлийн салбарууд хямралд орсноор эрэгтэйчүүдийн нийгэмд гүйцэтгэх үүрэг суларсан бөгөөд үүгээр эрэгтэйчүүдийн гэр бүлд гүйцэтгэх үүрэг мөн суларсан. Үүнийг жендерийн бодлогоор залруулна. Эмэгтэйчүүд болон эхчүүдийн гэр бүлийн амьдралд болон үр хүүхдээ өсгөж хүмүүжүүлэх ажилд оролцох оролцоог нэмэгдүүлэх бодлого явуулна. Залуучууд, дунд үеийнхэн болон хөгшид настайчууд гэсэн үе үеийнхний хооронд ялгаа үүсэх биш харин “эв нэгдэл” гэсэн нийгмийн зарчмыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллана.

3.9. Нярайлсан эхчүүдийн хүүхдээ асран хүмүүжүүлэх үүргийг Монголын үүрд оршин тогтнохын төлөөх ариун хөдөлмөр гэж үзэж, эдгээр эхчүүдийг хүүхдээ цэцэрлэгийн насанд хүрэх хүртэл нь төрөөс дэмжих бодлого баримтлана.

3.10. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн ёс суртахуун, үнэн зөв, эв нэгдэл, хөгжлийн төлөө ажиллах ёстой бөгөөд үүний тулд хэзээд иргэдэд ил тод, нээлттэй байх ёстой. Иргэд дуртай цагтаа хэвлэл мэдээллээс үнэн зөв мэдээлэл шаардах эрхтэй.

3.11. Монголын үе үеийн үр хүүхдүүдийг эрүүл саруул хүмүүжүүлэхийн эсрэг архи, хар тамхи, садар самуун болон гэмт хэрэг сурталчилсан хэвлэл мэдээллийг таслан зогсооно.

3.12. Үйлдвэрчний эвлэлийн бодлогыг дахин харж нэгдүгээрт ажил, хоёрдугаарт хөдөлмөр гэсэн хоёр зарчим дээр төвлөрүүлнэ. Гэртээ сууж бага насны хүүхэд өсгөж, хүмүүжүүлэх ажлыг хөдөлмөр гэж үзэн төрөөс санхүүжүүлэх бодлогыг



баримтална. Хөдөлмөрийн гэрээг олон улсын стандартад тохируулан боловсруулна. Иргэдийн нэг бүрчилсэн орлого болон цалингийн стандартыг боловсруулж нэвтрүүлэхийн төлөө ажиллана.

3.13. Үйлдвэрчний эвлэлтэй бүх талаар хамтран ажиллаж, цалин хөлс, тэтгэвэр тэтгэмжийг ҮНБ, ДНБ-ний өсөлттэй уялдуулах бодлого баримтлана.

3.14. Монгол үндэстний стратегийн ач холбогдол бүхий шинжлэх ухаан, технологийн дэд бүтцийг бүх бүс нутагт хөгжүүлнэ.

3.15. Замын түгжрэл болон замбараагүй барилгын асуудлыг хот төлөвлөлтийн шинэчилсэн бодлогоор шийднэ.

3.16. Нийгмийн хамгаалал, халамжийн тогтолцоог боловсронгуй болгож, ҮНБ, ДНБ-ний өсөлттэй оновчтой уялдуулан нэмэгдүүлж, төрөөс үзүүлэх тэтгэмжийг олон хүүхэдтэй ядуу гэр бүл, хүн амын орлого багатай ядуу болон дундаж орлоготой хэсэг бүлэг рүү чиглүүлнэ.

3.17. 35 – 55 насны иргэдийн хөдөлмөр эрхлэлт, тэтгэврийн асуудлын хууль эрх зүйн орчныг өөрчлөн сайжруулах бодлогыг боловсруулна.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, ХҮМҮҮЖИЛ – ХӨГЖЛИЙН ТҮЛХҮҮР

4.1. Их дээд сургуулиудын сургалтын чанарыг эрс дээшлүүлнэ.

4.2. Төрийн мэдлийн их дээд сургуулиудын сургалтын материаллаг бааз байгуулах ажлыг дэмжиж архигүй, эрүүл, оюунлаг оюутныг дэмжих бодлого баримтлана.

4.3. Байгаль шинжлэл инженерийн чиглэлээр суралцах оюутныг төрийн бодлогоор тусгайлан дэмжих бодлого хэрэгжүүлнэ.

4.4. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг бүсчилж өндөр мэргэжлийн ур чадвартай ажиллах хүчнийг бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох бодлого баримтална.

4.5. Ерөнхий боловсрол бол нийтийн асуудал, төрийн үйл хэрэг. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын боловсролын нэг стандарт хөтөлбөр, мөн хүмүүжлийг сайжруулах асуудлыг төрөөс чухалчилан анхаарна.

4.6. Дээд боловсрол бол төрийн үйл хэрэг. Дээд боловсрол бол улс орны хөгжлийн эх үүсвэр хөдөлгөгч хүч. Тиймээс чанартай дээд боловсрол эзэмшүүлэхэд анхаарч ажиллана.



4.7. Шинжлэх ухааны академи болон Их, дээд сургуулиудыг улс төрийн лоббиноос хамгаалах. Өндөр мэдлэг шаардсан шинжлэх ухаан болон их, дээд сургуулиудын салбарт удирдах зөвлөлийн гишүүн нэрийн дор улс төрийн лобби явагдахыг үл зөвшөөрнө. Шинжлэх ухааныг улс төрөөс хараат бус байх тогтолцоог бүрдүүлнэ.

4.8. Мухар сүсэг худал мэдлэгийг Монгол үндэстний мэдлэгийн бүх салбараас цэвэрлэн арилгана.

4.9. Шашин болон сүм хийдүүдийн асуудлыг нэг мөр болгож “эрх чөлөө” гэсэн ардчиллын зарчимд зохицуулах. Шашин нэрийн доор иргэдийн тархийг угааж мухар сүсэг рүү уриалан дуудсан үйл ажиллагаануудад шүүмжлэлтэй хандана. Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн шашны байгууллагуудыг сүм хийд ажиллуулахыг зөвшөөрнө. Ямар ч шашны байгууллага хүний эрх чөлөөнд халдаж ятгах, хахуульдах, айлган сүрдүүлэх үйлдэл хийж болохгүй.

4.10. Сургуулиудад боловсрол болон эрдмүүдийн тухай ойлголтуудыг тодорхой болгож социализмын үеийн сайн талуудыг нэвтрүүлэх. Сургуулиудын боловсролд шашны болон арга билгийн сургаалиудыг ялгаж, салгаж боловсрол гэдэг нэрийн дор зөвхөн хүн төрөлхтний боловсролыг ойлгоно. Социализмын үеийн сайн талууд жишээлбэл: Ариун цэвэрч, дэг журамтай, сахилга баттай, үнэнч шударга эрдмүүдийг сургуулиудад нэвтрүүлэхийг дэмжинэ. Өсвөр үеийнхэн хөгжмийн боловсрол зайлшгүй эзэмших ёстой бөгөөд тэдний бие бялдрыг өв тэгш хөгжүүлэхийн тулд Биеийн тамирын хичээлийг түлхүү оруулах бодлого баримтлана.

4.11. Даяарчлагдсан дэлхийд Монгол хүн хөл нийлүүлэн алхахын тулд дэлхийн мэдлэгийг нийгмийн бүхий л салбаруудад нэвтрүүлэх шаардлагатай. Тиймээс их, дээд сургуулиудад зөвхөн дэлхийн мэдлэгийг зааж сургана. Шашныг мэдлэгийн салбаруудаас тусгаарлана.

4.12. Их, дээд сургуулиудыг цэгцэлж, хүмүүнлэгийн байгууллага болгоно.

4.13. Ерөнхий боловсролын стандартыг Монгол уламжлалт шавь төвтэй сургалтын заагдах хичээлийн агуулгыг бүрэн шинэчилж уялдаа холбоог сайжруулан суурь хүмүүжил, ёс заншил, мэдлэг олгох тогтолцоонд шилжүүлнэ.

4.14. Шинээр баригдаж байгаа хорооллуудад хүүхдийн цэцэрлэг байгуулах бодлогыг баримтлана.

4.15. Өндөр ёс суртахуун өндөр мэдлэг боловсролтой багш хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.



- 4.16. Бүх түвшний сургалтад хамрагдаж байгаа багшийн цалин хангамжийг амьдралын баталгааг бүрэн хангах тогтолцоонд шилжүүлнэ.
- 4.17. Орчин үеийн лабораторийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон судалгаа шинжилгээний нэгдсэн лабораторийн төвийг их, дээд сургууль эрдэм шинжилгээний хүрээлэнгийн дунд байгуулах бодлого баримтална.
- 4.18. Монгол хүний төлөвшил хөгжлийн эх үндэс болсон түүх, соёл, урлаг, зан заншил, уламжлалыг таниулан сурталчилах үндэстний соёлын цогцолбор төв байгуулна.
- 4.19. “Чингисийн Монгол” сангаас ирээдүйн ажиллах мэргэжилтнүүдийг дэлхийн томоохон санхүүгийн корпорацуудад ажиллуулж бэлтгэнэ.
- 4.20. Хүүхдийн хүмүүжил боловсролын стандартыг бий болгоно.
- 4.21. Дэлхийн шилдэгт тооцогддог Их сургуулиудтай хамтарч ажиллах урт хугацааны хөтөлбөрийн эхлэлийг байгалийн шинжлэх ухаан, хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн шинжлэх ухаан, хүмүүнлэгийн шинжлэх ухаан, эдийн засгийн бүх салбарт хөгжүүлэхийг чухалчилан анхаарна.

ТАВ. ЭРҮҮЛ МОНГОЛ ХҮН – АЗ ЖАРГАЛТАЙ АМЬДРАЛ

- 5.1. Эрүүл мэндийн салбарын анхан шатны байгууллага, эрүүл мэндийн даатгалын салбар, эмнэлгийн үйлчилгээг сайжруулах зорилгоор үе шаттай 40 тэрбум төгрөг зарцуулна.
- 5.2. Монгол хүнийг эрүүлжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 5.3. Бүх хүнийг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулж мэдээллийн сан байгуулах бодлого барина. Халдварт өвчин – сүрьеэ, шар, арьс өнгөний өвчний тархалтыг бууруулах дорвитой арга хэмжээ авна.
- 5.4. Эрүүл мэндийн орчин үеийн оношлогооны төв, төрх эмнэлгүүдийг Улаанбаатар болон аймгийн төвүүдэд байгуулна.
- 5.5. Спорт чөлөөт цаг эрүүл мэндийн хөтөлбөрийг хэрэгжүүлж элдэв төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх асуудалд хүн амыг бүрэн хамруулахад анхаарч ажиллана.
- 5.6. Эрүүл зөв хооллолт урт насжилт хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 5.7. Эм био бэлдмэлийн худалдаанд хатуу хяналт тогтооно.



5.8. Өндөр хөгжилтэй орны Анагаахын Шинжлэх Ухаан, техник технологийн ололтыг Монголд нэвтрүүлэх ажлыг системтэйгээр эхлүүлэх.

5.9. Хөгжингүй орны нарийн мэргэжлийн эмнэлгийн салбаруудыг Монголд хамтран байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

5.10. Нийгмийн эрүүл мэндийн хүрээнд иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийг эрүүлжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

ЗУРГАА: ҮЙЛДВЭРЖИЛТ – АМЬДРАЛЫН БАТАЛГАА

ХӨГЖЛИЙН ЗҮТГҮҮР ТӨСЛҮҮД

6.1. Таван толгойн нүүрсний уурхайгаас жилд 100 сая тонн хагас боловсруулсан нүүрс экспортлох бодлогыг концессийн хууль эрх зүйн орчноор бүрдүүлнэ.

6.2. Оюутолгой ордыг эдийн засгийн эргэлтэд яаралтай оруулж зэсийн экспортыг нэмэгдүүлнэ.

6.3. Төмөртэй, Хустайн төмрийн ордыг түшиглэн Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг өргөтгөн эцсийн бүтээгдэхүүн боловсруулах бодлого хэрэгжүүлэхийн зэрэгцээ төмрийн хүдрийн экспортыг нэмэгдүүлнэ.

6.4. Бага-Нуурын хүрэн нүүрсний ордыг түшиглэн метан хий, шингэрүүлсэн түлш, нийлэг эдлэл боловсруулах үйлдвэрийг байгуулахын зэрэгцээ 6-р Дулааны Цахилгаан Станцыг ашиглалтад оруулж дотоодын цахилгаан хэрэгцээг хангахын зэрэгцээ хөрш орнуудад экспортлогч үйлдвэрүүдийн бүтэц бүхий “Нүүрс-Эрчим хүчний цогцолбор” байгуулна.

6.5. Бага-нуурын ДЦС-ын дулааныг ашиглан хүлэмжийн аж ахуйг цогцолбор байдлаар байгуулж хүнсний өргөн хэрэглээний нарийн ногоогоор дотоодын хэрэгцээг бүрэн хангана.

6.6. Цайрын экспортыг нэмэгдүүлнэ.

6.7. Газрын ховор металийн судалгааг хийж экспортыг нэмэгдүүлнэ.

ХҮНС, ХӨНГӨН ҮЙЛДВЭРЛЭЛ, ЖДҮ

6.8. Аймаг бүрт хүнсний үйлдвэр байгуулж аймгийн иргэд хөдөлмөрчдийг бүрэн хангах бодлого хэрэгжүүлнэ.



6.9. Уул уурхай, ашигт малтмалаас аймаг орон нутагт орох орлогыг төвлөрүүлж “Шинэ хөдөө хөгжлийн сан” байгуулж ерөнхий сайдын дэргэдэх аймаг орон нутгын ИТХ-ын дарга нараас бүрдсэн зөвлөлийг байгуулж тухайн аймгын хүн амд харьцуулсан тоогоор жигд хувиарлах зарчмыг баримталж ажиллана.

6.10. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Бага-Нуур, Налайх зэрэг хүн ам төвлөрсөн бүс нутгуудад аж үйлдвэрийн парк байгуулах төслийг хэрэгжүүлнэ.

6.11. Хөрөнгө оруулалтын зээлээр орчин үеийн техник, шинэ технологийн шинэчлэлт хийх нөхцөлөөр хангана.

6.12. Барилгын материал, оёмол сүлжмэл бүтээгдэхүүн, хөнгөн болон хүнсний үйлдвэрлэлийн салбарыг татварын хөнгөлөлттэй бодлогоор дэмжих төсөл боловсруулна.

6.13. ЖДҮ-г дэмжих бодлогыг шинэ түвшинд гаргахын тулд тухайн жилийн төсвийн боломжийг харгалзан үзэж урт хугацааны хөнгөлөлттэй зээл хэлбэрээр олгох бодлого баримтална.

6.14. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг олон улсын стандарт түвшинд хүргэнэ.

ҮЙЛЧИЛГЭЭ

6.15. Хөшигт дэх олон улсын нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж улс хоорондын ачаа тээврийн олон улсад өрсөлдөхүйц аж ахуйн нэгж байгуулж олон улсын зорчигч болон ачаа тээврийг хөгжүүлнэ.

6.16. Бүх аймгийн төвүүдийг холбосон хатуу хучилттай авто замын сүлжээг бий болгоно.

6.17. Үйлдвэрлэл хөгжүүлснээр хүн амын бодит орлогыг эрс нэмэгдүүлж БНСУ-ын иргэдийн түвшинд хүргэн “Монгол хүний” амьдралын баталгааг хангах зорилтыг шийдвэрлэж тэтгэмжээр өлөн зэлмүүн амьдрахыг халж хөдөлмөрийн үр шимээ хүртэн элбэг хангалуун, аз жаргалтай амьдрах нөхцлийг бий болгоно.

6.18. Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудтай ижил түвшинд эдийн засгийн хамтын ажиллагаанд оролцоно. Үүний тулд евро стандартыг нэвтрүүлж хэрэгжүүлнэ.



ДОЛОО. ХӨДӨӨ АЖ АХУЙН ҮЙЛДВЭРЛЭЛ – НОГООН БҮС, АЮУЛГҮЙ ХҮНС

7.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг шинэчилэн хангайн бүсэд ашигт малтмалын үйл ажиллагаа явуулахыг хуулиар хориглож ой мод, усны нөөцийн санг хамгаалах бодлогыг төрөөс хатуу чанд баримтлан хэрэгжүүлнэ.

7.2. Мах сүүний чиглэлийн эрчимжүүлсэн аж ахуйг малын үүлдэр угсааг сайжруулах замаар хөгжүүлэн экспортыг дэмжинэ. Газар тариаланд дэвшилтэт технологи нэвтрүүлж хоршооллын хэлбэрийг төрөөс дэмжинэ.

7.3. Хүнсний аюулгүй байдал, баталгаат хангамжийг бүрдүүлэх зорилгоор хүнсний улсын нөөцийн агуулах Улаанбаатар, Дархан, Орхон аймаг болон бүсийн төвүүдэд бий болгох. Эрүүл ахуйн шаардлага хангасан олон улсын жишигт нийцэхүйц хүнсний бөөний төвүүдийг байгуулах бодлого баримтлана.

7.4. Багануурт хүнсний нарийн ногооны хүлэмжийн аж ахуй байгуулна.

7.5. Спиртийн үйлдвэрлэлийг төрийн мэдэлд авна.

7.6. Бүсүүдийн төвд тэжээлийн аж ахуйн цогцолборуудыг байгуулна.

7.7. Хадлан тэжээл бэлтгэх, ургац хураалтын ажлыг чанаржуулж эрчимжсэн мал аж ахуй, газар тариаланг дэмжих бодлого боловсруулна.

7.8. Байгаль орчны нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулж байгаа компаниудыг дэмжинэ.

7.9. Сэлбэ, Туул, Улиастай, Дунд голуудын дагуу соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгүүдийг байгуулна.

7.10. Сэлбэ, Туул, Улиастай, Дунд голуудын дагуу соёл амралтын ногоон бүсийг хамгаална.

7.11. Улсын хэмжээнд усан сан, цөөрөм, хиймэл нуур олноор байгуулж усны нөөцийг нэмэгдүүлнэ.

7.12. Цөөн малтай малчид, тариалангийн бага газартай тариаланчдын бизнесийг хамгаалах, зах зээлд оролцох боломжийг нэмэгдүүлнэ.

7.13. Байгалиа хайрлах уламжлалт зан үйл, ёс заншлыг төрийн бодлогоор дэмжинэ.

7.14 Дэлхийн цаг агаарын дулаарал, уул уурхайн нөхөн сэргээлт, цэвэр усны хямгач бодлого алдагдсан, гол горхи сүүлийн жилүүдэд олноор ширгэж байгаатай холбогдуулж шинээр усны яам байгуулах бодлогыг дэмжиж ажиллана.



НАЙМ. ДЭД БҮТЭЦ, АРДЫН ОРОН СУУЦ – ХҮНИЙ ТӨЛӨӨ

- 8.1. Хөндлөн тэнхлэгээр “Мянганы төмөр зам” урт хугацааны төслийг боловсруулж, хэрэгжүүлэхэд анхаарч ажиллана.
- 8.2. Босоо тэнхлэгээр Замын Үүд – Алтанбулаг чиглэлд Ази, Европийг холбосон транзит ачаа тээврийн хурдны зам барих ажлыг эхлүүлнэ.
- 8.3. Олон улсын агаарын ачаа тээврийн зангилаа терминал байгуулах ажлыг эхлүүлэх төсөл боловсруулж эхлэлийг тавина.
- 8.4. Концессийн гэрээгээр 500,000 айлын “Ардын орон сууц” хөтөлбөрийг санхүүжилтын шинэ аргачлалаар хэрэгжүүлнэ. Зээлийг хялбаршуулах зорилгоор орон сууцыг нь барьцаалж 25 жилийн хугацаатайгаар олгоно.
- 8.5. Орон сууцны нэг гэр бүлд ногдох стандартыг 80 м2 байхаар шинэчлэнэ.
- 8.6. Гэр хорооллын барилгажуулалтыг дэмжихийн тулд дэд бүтэц инженерийн шугам, сүлжээг улсаас санхүүжүүлэх нөөц боломжийг эрэлхийлэн тухайн төсвийн боломжийг үе шаттайгаар ашиглах төслийг хэрэгжүүлнэ. Ингэснээр агаар, хөрсний бохирдол, эрүүл ахуйн асуудлуудыг цогцоор нь шийдвэрлэгдэх үндэс суурь тавигдана.
- 8.7. Олон улсад үйл ажиллагаа явуулдаг Ази – Европыг холбосон интернет провайдер компаниудын ажлыг дэмжинэ.
- 8.8. Барилгын материалын үйлдвэрлэлийг бүсчлэн хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

ЕС. ГАДААД ХАРИЛЦАА – САЙН ХӨРШИЙН ТҮНШЛЭЛ

- 9.1. Гадаад бодлогын үндсэн зарчим нь эрх тэгш, харилцан ашигтай хамтран ажиллаж, энх тайвнаар зэрэгцэн орших хөгжлийн бодлого явуулна.
- 9.2. Үндэстний стратегийн ач холбогдол бүхий шинжлэх ухаан технологи, боловсрол, хүний хөгжил, эдийн засаг бүх салбарт гадаад бодлогыг эрчимжүүлнэ.
- 9.3. Монгол үндэстний хүний эрх, эрх чөлөөний төлөө гадаад бодлогыг эрчимжүүлнэ.
- 9.4. Дэлхийн энх тайван, хөгжил дэвшлийн төлөө гадаад бодлогыг эрчимжүүлнэ.



9.5. Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт гадаад бодлогын хүрээнд дэлхийн улс орнуудтай найрсгаар харилцаж, харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэн эдийн засгийн аюулгүй байдлыг бүх талаар хангахыг эрмэлзэж, аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжилнэ.

9.6. Далайн тээврийн асуудлыг төрийн бүрэн эрх мэдэлд авч далбаа ашиглалтын орлогыг нэмэгдүүлнэ.

9.7. ОХУ, БНХАУ-тай тэнцвэртэй харилцаж, түүхэн уламжлал, эдийн засгийн хамтын ажиллагааны өвөрмөц онцлогийг харгалзан сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

9.8. АНУ, Япон, Европын холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

9.9. Ази, Номхон далайн бүс нутагт хоёр талын болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлж, стратегийн тогтвортой байдлыг бэхжүүлэх, аюулгүй байдлын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагааг дэмжинэ.

9.10. Үндэсний компани, аж ахуйн нэгжүүдийг гадаадад хөрөнгө оруулах, олон улсын банк, санхүү, хөрөнгийн зах зээлд нэвтрэх нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.

9.11. Гадаадад байгаа Монгол Улсын иргэд, хуулийн этгээдүүдийн хууль ёсны эрх ашгийг тууштай хамгаалж, иргэдийг эх орондоо эргэн ирж, хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахыг дэмжих, гадаадад гэрээгээр ажиллагсадын нийгмийн хамгааллыг сайжруулах, Монгол туургатнуудтай харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд чиглэгдсэн төрийн бодлого хэрэгжүүлнэ.

9.12. Дэлхийн улс орнуудтай дипломат харилцааг шинэ шатанд гаргаж концессийн гэрээг эдийн засгийн бодлогын суурь болгох үндсийг тавьна.

9.13. Олон улсын харилцаанд эдийн засгийн хамтын ажиллагааг түлхүү анхаарч хэрэгжүүлнэ.

9.14. Эх орноо бүх талаар гадаад ертөнцөд сурталчлан таниулж, түүх, соёлын үнэт зүйлс, байгалийн өвийг хамгаалах, сэргээх талаар гадаад улс, олон улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллана.

